



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот


Итгэлцүүр батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2025 онд хэрэглэх итгэлцүүр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасан сарын дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, мөн өдрөөс хойш 2023 оныг дуустал хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд албан журмын даатгуулагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тус тус тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

ШТА1206 9923103294 5498449

Засгийн газрын 2024 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн 231 дүгээр
тогтоолын хавсралт

ДААТГУУЛАГЧИЙН ШИМТГЭЛ ТӨЛӨХ БОЛОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ
ТОГТООЛГОХ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫН ӨНӨӨГИЙН
ҮНЭ ЦЭНИЙГ ТОДОРХОЙЛОХОД 2025 ОНД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Он	Итгэлцүүр
1990 он ба түүнээс өмнөх он	2387.05
1991	1194.46
1992	610.61
1993	247.77
1994	149.88
1995	58.55
1996	44.45
1997	37.47
1998	29.85
1999	26.02
2000	19.73
2001	18.76
2002	17.35
2003	15.41
2004	13.57
2005	12.46
2006	10.21
2007	7.77
2008	5.24
2009	4.85
2010	4.27
2011	3.58
2012	2.86
2013	1.87
2014	1.69
2015	1.66
2016	1.64
2017	1.54
2018	1.42
2019	1.35
2020	1.32
2021	1.16
2022	1.06
2023	1.00